**ХЭНТИЙ АЙМАГ**
**БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 15 өдөр Дугаар А/13 Бор-Өндөр

Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий
нэгж талбарыг хувааж, хэлбэр,
зориулалтыг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгох журам"-ын 8.1.6, 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээ бүхий нэгж талбарыг хэсэгчлэн хувааж, хэлбэр, зориулалт болон байршлыг өөрчлөх хүсэлт гаргасан иргэний хүсэлтийг харгалзан үзэж, эзэмшлийн газрыг нэгдүгээр хавсралтад заасны дагуу шийдвэрлэсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээг захирамжаар зөвшөөрөгдөж, хуваагдсан, зориулалт болон байршил өөрчлөгдсөн газрын хэмжээгээр шинэчлэн олгож, өөрчлөлтийг Газрын кадастрын мэдээллийн санд оруулан, газар эзэмшүүлэх гэрээ байгуулахыг Газрын даамал /Т.Эрдэнэзаяа/-д даалгасугай.

3. Газар эзэмших гэрээний нөхцөл, зориулалтын дагуу газраа эзэмшин, гэрээг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмшигч (Р.Алтан-Очир)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.АДЪЯАБИЛЭГТ

D:/bichig hereg/Захирамж.docx

Сумын Засаг даргын 2025 оны ..01..
дугаар сарын 15...-ны өдрийн
А/13..-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Өөрчлөлт орж байгаа байгаа нэгж талбарын мэдээлэл

| д/д | Газар эзэмшигч иргэн, хуулийн этгээдийн нэр | Регистр | Анхны нэгж талбарын газрын | | | Нэгтгэгдэж буй нэгж талбарын | | | Байршлын координат |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээ /мкв/ | зориулалт | эзэмших хугацаа /жил/ | байршил | Зориулалт | хэмжээ /мкв/ | /UTM/ |
| 1 | Боржигин Рагчаа Алтан-Очир | СЩ87011710 | 10000 | 1606: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолбор | 13 | 5-р баг Хүйх, Шинэ зам-1 гудамж,112 | Үйлчилгээ | 8164 | x=376074.6 y=5118986.5<br>x=376134.0 y=5119034.2<br>x=376241.9 y=5119278.5<br>x=376266.8 y=5119259.3 |
| | | | | | | 5-р баг Хүйх, Шинэ зам-1 гудамж,112а | ШТС | 1836 | x=376049.6 y=5119004.3<br>x=376084.9 y=5119055.5<br>x=376134.0 y=5119034.2<br>x=376074.6 y=5118986.5 |